



УЛСЫН ОНЦГОЙ КОМИСССЫН АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх бэлтгэл, бэлэн байдлыг хангах тухай

Улсын хэмжээнд 2021 оны 8 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах шийдвэр гарч, бэлтгэл ажлыг хангаж байна. Элсэлтийн ерөнхий шалгалтад 40.420 шалгуулагч бүртгүүлж 21 аймаг болон нийслэлийн хэмжээнд 81 шалгалтын байранд зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний хуралдаанаар 2021-2022 оны хичээлийн жилийг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс үе шаттайгаар эхлүүлэх шийдвэр гарсан. Энэ хичээлийн жилд 1515 цэцэрлэгт 232.000 хүүхэд, 854 сургуульд 718.817 сурагч, 75 МСҮТ-д 40.165 суралцагч, 88 дээд сургуульд 150.100 оюутан суралцана. Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан 74.523 оюутан аймаг, орон нутгаас Улаанбаатар хотод ирнэ. Оюутны 71 байранд 11.359 оюутан амьдарна. Үүнээс Улаанбаатар хотод 58 байранд 9391, орон нутагт 14 байранд 2028 оюутан амьдрах урьдчилсан судалгаа гарсан.

Улсын хэмжээнд 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар коронавируст халдвараар өвчилсөн 0-18 хүртэлх насны 38.582 хүүхэд байгаа нь нийт тохиолдлын 21.4%-ийг эзэлж байна. Халдвар авсан нийт хүүхдийн 28.269 /73.3%/ Улаанбаатар хотод, 10.284 /26.6/ хүүхэд хөдөө орон нутагт бүртгэгдсэн бөгөөд 29 /0.1%/ нь гадаадаас зөөвөрлөгдсөн тохиолдол байна. Өвчилсөн хүүхдүүдийг насны бүлгээр авч үзвэл:

- 0-4 насны хүүхэд 8857 буюу 23.1%,
- 5-11 насны хүүхэд 16876 буюу 44.0%,
- 12-15 насны хүүхэд 9070 буюу 23.6%,
- 16-17 насны хүүхэд 3564 буюу 9.3% тус тус байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн мэдээллээр SARS-CoV-2 вирусийн "Альфа" хувилбараас 60 хувиар илүү халдварлах чадвартай "Дельта" хувилбар дэлхийн 132 улс оронд бүртгэгдэж, халдварын тархалт эрчимтэй нэмэгдэж байна.

Хичээлийн шинэ жилийн нээлттэй холбогдуулан хүн амын шилжилт хөдөлгөөн, төвлөрөл үүсч улсын хэмжээнд халдварын тархалт нэмэгдэх өндөр эрсдэлтэй байгааг харгалзан халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор Засгийн газрын гишүүд, яам, агентлагийн дарга нар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийг үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүн Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газрын дарга нарт:

- 1.1. Сургалтын байгууллагын орчинд халдвар хамгааллын дэглэм баримтлах, танхимд хичээллэх үеийн горим, халдвар илэрсэн тохиолдолд авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ зэрэг шаардлагатай журам, заавар, удирдамжийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулан батлуулж, мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулах.
- 1.2. Оюутны дотуур байрыг бэлтгэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, халдвар илэрсэн тохиолдолд тандалт судалгаа хийх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, заавар, удирдамжийг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.
- 1.3. Цар тахлын улмаас учрах аюул, хор холбогдол, халдвар тархах хэлбэр, халдвар хамгааллын дэглэмийн ач холбогдлын талаар хүүхэд, оюутан, суралцагчдын насны онцлогт нь тохирсон мэдээлэл, сурталчилгааны ажлыг бүх шатанд зохион байгуулах.
- 1.4. Хүүхэд, оюутан, суралцагч, багш, боловсролын байгууллагын ажилтан, алба хаагчдыг SARS-CoV-2 вирусын эсрэг вакцинд хамруулах ажлыг эрчимжүүлэх.
- 1.5. Сургалтын байгууллагын эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнуудад байгууллагын орчинд халдвараас урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа зохион байгуулах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулж, мэдээ, мэдээлэл, арга зүйгээр хангах.
- 1.6. Сургалтын байгууллагын орчинд халдвар хамгааллын дэглэм мөрдөх, халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагажуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

Хоёр. Аймаг, нийслэлийн Засаг дарга нэрт:


- 2.1. 2021-2022 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэлийг хангахтай холбогдуулан дараах асуудалд анхаарч, шийдвэрлэх:
 - 2.1.1. Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан коронавируст халдвар /Ковид-19/-ын эмчилгээний зориулалтаар ашиглаж байгаа оюутны дотуур байр, цэцэрлэг, сургуулийн байр, автобус, тээврийн хэрэгслийг яаралтай суллах, халдваргүйжүүлэлт хийж хүлээлгэн өгөх.
 - 2.1.2. Оюутны дотуур байр, цэцэрлэг, сургуулийн байрыг сулласантай холбогдон коронавируст халдвар /Ковид-19/-ын эмчилгээнд ашиглах орны нөөцийг бүрдүүлэх, халдварын тархалт нэмэгдсэн тохиолдолд нэмэлт ор дэлгэх, хариу арга хэмжээнд ашиглах тээврийн хэрэгсэл татан төвлөрүүлэх төлөвлөгөөнд шат шатандаа тодотгол хийж, бэлтгэл бэлэн байдлыг хангах.
 - 2.1.3. Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад 12-17 насны хүн амыг хамруулах зөвлөмж, уриалгыг гаргаж, эрчимжүүлэх.
 - 2.1.4. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны халдваргүйжүүлэлтэд шаардагдах нөөцийг бүрдүүлэх.
 - 2.1.5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагчдаас тандалтын зорилгоор 14 хоногийн давтамжтайгаар түргэвчилсэн шинжилгээг 10 хүртэл хувийг хамруулан зохион байгуулахад шаардагдах зардлын нөөцийг шийдвэрлэсэн байх.
 - 2.1.6. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ, дүгнэлт хийлгэх, хоол үйлдвэрлэлийн газрын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хангах.

- 2.2. Их дээд сургууль, коллежид 2021 онд элсэгчдээс авах Элсэлтийн ерөнхий шалгалтын зохион байгуулалттай холбогдуулан дараах асуудалд анхаарч, шийдвэрлэх
- 2.2.1. Элсэлтийн ерөнхий шалгалтын зохион байгуулалттай холбоотой УОК, ЭМЯ, БШУЯ, БҮТ-өөс гаргасан улсын хэмжээнд нэгдсэн байдлаар дагаж мөрдөх заавар, зөвлөмж, удирдамжаас өөрөөр аймаг бүр тусдаа шийдвэр гаргахгүй байх.
- 2.2.2. Элсэлтийн ерөнхий шалгалтыг орон нутагт зохион байгуулахаар томилогдсон комиссын гишүүдийг саадгүй нэвтрүүлэх, шалгалтыг хэвийн зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллах.
- 2.2.3. Сум, багийн төвөөс аймгийн төвд ирж шалгалтад хамрагдах шалгуулагчдыг хэвийн нэвтрүүлж шалгалтад хамруулах.
- 2.2.4. Сум, багийн төвөөс аймгийн төвд ирсэн шалгуулагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн шугамаар дотуур байр, сургууль, цэцэрлэгт байршуулах ажлыг зохион байгуулж бусад нийтийн арга хэмжээнд хамруулахгүй байх.
- 2.3. Элсэлтийн ерөнхий шалгалт, хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагын хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж, нэгдсэн удирдлага, заавраар хангаж ажиллах.
- 2.4. Хүний бөөгнөрөл үүсэх, халдварын тархалтыг нэмэгдүүлэх эрсдэл өндөр аливаа үйл ажиллагаа, худалдаа үйлчилгээний байгууллагад тавих хяналтыг нэмэгдүүлж, халдвар хамгааллын дэглэм мөрдөх, байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг өргөн хүрээнд зохион байгуулж ажиллах.

Энэхүү албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг Улсын онцгой комиссын ажлын албанд 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг холбогдох комиссын гишүүд, дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

С.АМАРСАЙХАН



УХАД 168